

“АПУ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 08 сарын 18 -ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн Соёлын ордонд 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 14:00 цагт эхлэв.

АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын агуулгыг танилцуулж, хурлын ирцийн талаарх мэдээг Тооллогын комиссын дарга О.Уранбайгалийг танилцуулна уу гэж индэрт урив.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга О.Уранбайгаль Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав:

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд 705,777,364 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 109 хувьцаа эзэмшигч оролцож, нийт саналын эрх бүхий 741,670,190 ширхэг энгийн хувьцааны 95.16% болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлж байна. Иймд Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хүчин төгөлдөрт тооцов.

АПУ ХК-ийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан Хурлын даргаар томилогдсон АПУ ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбилэг, Санхүү хариуцсан захирал Б.Түвшин, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга Ж.Үнэнбат нарыг тайзнаа урилаа.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Ё.Гэрэлчулуун, Ө.Батбаяр нар хуралд оролцов.

Хурал даргалагч Ц.Эрдэнэбилэг ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын дарга хэлэлцэх асуудлыг танилцуулах
 - I. АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрөх тухай;

- II. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл (цаашид нэгтгэх төсөл гэх), нэгтгэх гэрээг батлах тухай;
 - III. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах тухай;
 - IV. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;
 - V. АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай.
- 2. Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт /хүн тус бүр 2 мин/
 - 3. Тооллогын комисс санал өгөх журмыг тайлбарлах
 - 4. Санал хураалт явуулах
 - 5. Тооллогын комиссоос санал тоолох үйл ажиллагааг явуулах /40 мин/
 - 6. Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах
 - 7. Хурлаас гарах шийдвэрийг хурлын дарга танилцуулах /3 мин/
 - 8. Хурлыг хаах

Хэлэлцсэн нь:

- 1. АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрөх тухай;

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах болон сүүний бизнес нэгжийг тусгаарлах үндэслэл, тусгаарлах нөхцөл журам, тусгаарлах хөрөнгө, эрх үүрэг хариуцлага, сүү сүүн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага, шинээр үүсгэн байгуулагдах охин компанийн Дүрмийг товч танилцуулав. [Хурлын товхимол материал, танилцуулгыг хавсаргав]

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Асуух асуулт байна уу?

Асуулт байсангүй

Хэлэлцсэн нь:

- 2. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх төсөл, нэгтгэх гэрээг батлах тухай;

Танилцуулсан нь:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах талаар болон төслийн хүрээнд ажилласан мэргэжлийн зөвлөх байгууллагуудыг танилцуулав. Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах үндэслэл шаардлага, нэгдлийн бүтэц зохион байгуулалт, 5 жилийн буюу 2017-2021 оны

нэгтгэсэн бизнес төлөвлөгөө, зах зээлийн таамаглал, бизнесийн нэгдэл байгуулагдсаны ач холбогдол, үр дүнг танилцуулав.

[Хурлын товхимол материал, танилцуулгыг хавсаргав]

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төслийн агуулга, нэгтгэх гэрээний агуулгыг танилцуулав.

Нэгтгэх төсөл нь 7 зүйл, 17 заалттай.

1. Ерөнхий зүйл
2. Төслийн ач холбогдол
3. Компаниудын танилцуулга
4. Компаниудын хувьцаа эзэмшигчдийн бүтэц
5. Компанийг нэгтгэх нөхцөл, нэгдэж байгаа компанийн үнэт цаасыг нэгтгэж байгаа компанийн үнэт цаас, бусад хөрөнгөд хөрвүүлэх
6. Компанийг нэгтгэсэнтэй холбогдон үүсэх хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх
7. Төслийг гүйцэтгэх, нэгтгэх үйл ажиллагааг дуусгавар болгох

Нэгтгэх гэрээний тал: АПУ ХК, Эвэргрийн Инвестментс ХХК

Гэрээний үнийн дүн: 338,127,000,000 төгрөг

Гэрээний агуулга: Эвэргрийн Инвестментс ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, эрх, үүрэг хариуцлагыг АПУ ХК-д шилжүүлж, нэгтгэх буюу Эвэргрийн Инвестментс ХХК-ийн эзэмшлийн компаниудын хувьцаагаар гэрчлэгдэх эрх, үүрэг АПУ ХК-д шилжинэ; АПУ ХК-аас нэмж гаргасан хувьцааг Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болох Хайнекен Азия Пасифик Лимитед Пте.Лтд, Монголиан Бэвэриж Инвестмент ХХК-д эзэмшүүлнэ.

Хэлцлийн үнийн дүн сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш үнэтэй тул их хэмжээний хэлцэлд хамаарна. Иймд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ

Эвэргрийн Инвестмент ХХК-ийн хувьцаа эзэмшигч Монголиан Бэвэриж Инвестментс ХХК нь Шунхлай групп ХХК-ийн 100%-ийн эзэмшилтэй охин компани тул тухайн хэлцлийн хувьд сонирхол бүхий этгээдэд хамаарна. Иймд уг асуудлыг сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Нэгтгэх гэрээний бичвэрт бичгийн алдаа хийснийг залруулах хэрэгтэй байна. Эвэргрийн Инвестментс ХХК-ийн эзэмшлийн М Би Си компанийн хувьцааны тоо ширхгийг алдаатай бичсэн буюу 53,953,700 ширхэг гэснийг 52,253,700 ширхэг болгож залруулж байна. Алдаатай бичиж оруулсанд хүлцэл өчье. (Тараагдсан хурлын материалын 59 хуудаст бичигдсэн байгаа тоо)

[Хурлын товхимол материал, танилцуулгыг хавсаргав]

Хэлэлцсэн нь:

3. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах тухай;

Танилцуулсан:

Андеррайтер БиДиСек ҮЦК ХК-ийн Тэргүүн дэд захирал Лхагвадорж: Энэхүү төсөлд андеррайтер компаниар БиДиСек ҮЦК ХК, үнэлгээний компаниар БДО Аудит ХХК ажиллаж байна. Түүнчлэн уг ажиллагаанд хуулийн байгууллага, аудитын байгууллагын дүгнэлт гарч хавсаргагддаг. БДО Аудит ХХК-ийн төлөөлөл өнөөдрийн хуралд ирсэн байна. Та бүхэн асуулт байвал асуулт хариултын үед үнэлгээний байгууллагын төлөөллөөс асууж болно.

Нэгдэх ажилтай холбоотойгоор талууд үнэлгээ хийлгэдэг бөгөөд үүний хүрээнд хийгдсэн БДО Аудит ХХК-ийн бизнесийн үнэлгээний товчийг танилцуулав.
[Танилцуулгыг хавсаргав]

АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцааны мэдээллийг танилцуулав.

Зориулалт: Хайнекен Азиа Пасифик Пте.Лтд, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК нарт зориулж, хаалттай хүрээнд эзэмшүүлэх зорилгоор

Хувьцааны төрөл: энгийн

Тоо ширхэг: 321,304,553 ширхэг

Нэмж гаргах хувьцааны нэгж үнэ: 1,052.35 төгрөг

Хувьцааны нэрлэсэн үнэ: 10 мөнгө

Нэмж хувьцаа гаргасны дараа Хайнекен Азиа Пасифик Пте.Лтд-25%, Монголиан Бэвэриж Инвестментс ХХК-5.19%-ийн хувьцаа эзэмшигч болох юм. Одоогийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо ширхэг өөрчлөлт орохгүй, хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь буурах юм.

[Хурлын товхимол материал, танилцуулгыг хавсаргав]

Хэлэлцсэн нь:

- 4. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;**

Танилцуулсан:

Андеррайтер БиДиСек ҮЦК ХК-ийн Тэргүүн дэд захирал Лхагвадорж: АПУ ХК-аас нэгтгэх шийдвэр гаргах болон нэмж хувьцаа гаргаж байгаатай холбогдуулан одоогийн хувьцаа эзэмшигчдэд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрх үүсэх, шаардах эрх үүсэх асуудлыг шийдвэрлэдэг. Энэ удаад нэмж гаргах хувьцаа гаргаж байгаа шалтгаан нь олон нийтээс хөрөнгө татах зорилгоор бус нэгдэж байгаа талд санал болгож байгаа тул нэмж гаргах хувьцаанаас АПУ ХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тогтоолын төслийг оруулсан.

Түүнчлэн стратегийн хөрөнгө оруулагчид нэр заан эзэмшүүлж байгаа бөгөөд тэр компани маань гадны компани бөгөөд байгуулж буй гэрээний нөхцөлийг тодорхой байх шаардлагаар шийдвэрийн дараа тэргүүн ээлж эдлэхээр болоход хувьцаа тоо ширхэгт өөрчлөлт орох тул тэргүүн ээлж эдлүүлэхэд хүндрэлтэй байгаа болно.

Түүнчлэн нэмж гаргах хувьцааны үнэ 1,052.35 төгрөг байхаар тогтоосон бөгөөд зах зээл дэх нийлүүлэлт харьцангуй доогуур (зах зээлийн үнэ 360-400 хооронд байгаа) нөхцөлд тэргүүн ээлж эдлүүлэх шаардлага байхгүй юм гэж үзсэн.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно гэж заасан байдаг.

Хэлэлцсэн нь:

5. АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай.

Танилцуулсан:

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: АПУ ХК-ийн хаалттай хүрээнд хувьцаа нэмж гаргахыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас зөвшөөрч шийдвэрлэн, үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт орохыг эрх бүхий байгууллагуудаас зөвшөөрсөн тохиолдолд хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт орох тул Дүрмийн холбогдох хэсэгт энэхүү өөрчлөлтийг тусгах шаардлага үүснэ.

Дүрмийн нэмэлт өөрчлөлтийн агуулга:

Дүрмийн 3-р зүйлийн 3.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөх

“Компанийн зарласан хувьцааны нэрлэсэн үнэ 10 мөнгө байх ба нийт 742,877,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэснийг;

“Компанийн зарласан хувьцааны нэрлэсэн үнэ 10 мөнгө байх ба нийт 1,064,181,553 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ” гэж өөрчлөх.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Асуух асуулт байна уу? Тодруулга, санал байна уу?

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Баяржаргал: Нэгдэж байгаа компани татан буугдсан уу? Ийнхүү нэгдэхээ хүлээн зөвшөөрсөн байгаа юу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Нэгдэж байгаа компаниас албан ёсоор манай компанид санал хүргүүлж, түүнийгээ хүлээн зөвшөөрч байгаа. Хэлбэрийн хувьд нэгдэж байгаа ХХК бөгөөд хувьцаа эзэмшигчид нь холбогдох шийдвэрүүдээ хуулийн дагуу гаргаж байгаа.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Улаанхүү: Дахин үнэлгээний нэмэгдэл нь АПУ ХК-ийн өөрийнх нь баланс дээр тусгагдах уу?

Хариулт:

Санхүү хариуцсан захирал Б.Түвшин: Энэ нь хөрөнгийн дахин үнэлгээний хийгдэж байгаа асуудал бус, 2 компанийн үнэлгээний асуудал тул дахин үнэлгээний өөрчлөлт нь баланс дээр тусгагдахгүй.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Улаанхүү: Нэмж гаргаж байгаа хувьцааны үнэ тогтооход ашигласан бизнесийн үнэлгээний дүн нь тусгагдахгүй гэж үү?

Хариулт:

Санхүү хариуцсан захирал Б.Түвшин: Олон улсын нягтлан бодох стандартын дагуу хөрөнгийн үнэлгээ хийсэн тохиолдолд дахин үнэлгээний өөрчлөлтийг тусгана. Энэ бизнесийн үнэлгээ нэгдлийн процесст зориулж хийгдэж, тодорхой дүнг тохирох зорилготой тул энэ өөрчлөлт тусахгүй.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Энхтунгалаг: Сүүний бизнес салж байгаа юм. Хуучин хувьцаа эзэмшигчид нь сүүний бизнестээ хамаарах уу?

Хариулт:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: АПУ ХК-ийн 100%-ийн охин компани байдлаар сүүг тусгаарлах гэж байгаа тул хувьцаа эзэмшигч нь 1 этгээд буюу АПУ ХК байх юм. Хуулийн дагуу охин компанийнхаа санхүүгийн тайланг нэгтгэж, хуралдаа тайлагнаж байна.

Асуулт:

Хувьцаа эзэмшигч Голомт банкны итгэмжлэгдсэн төлөөлөгч Энхбаяр: Санал хураалтад сонирхлын зөрчилтэй холбоотойгоор ямар ямар хувьцаа эзэмшигчид саналын эрхгүй байгаа вэ?

Хариулт:

Андеррайтер БиДиСек ҮЦК ХК-ийн Тэргүүн дэд захирал Лхагвадорж: Шунхлай групп ХХК болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь нэгтгэхтэй холбоотой асуудалд саналын эрхгүй байгаа бөгөөд тэдгээрийн жагсаалт гарчихсан тооллогын комисст байгаа ба хэлэлцэх асуудал бүрээр саналын эрхийн гаргаж тоолохоор ажлаа зохион байгуулсан болно.

Өөр асуулт байсангүй.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Саналын хуудсаар санал өгөх санамжийг өгнө үү.

ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ч.Ариунсан: Санал хураалт энгийн аргаар явагдана. Санал өгөх “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” гэсэн баганы зөвшөөрч буй баганад зөв гэсэн тэмдэглэгээг хийнэ үү.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Санал хураалт эхэллээ.

Санал хураалт явагдав.

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Санал тоолох ажиллагаа 40 минут үргэлжилнэ

Санал хураалт дуусав.

Тооллогын комиссын дарга О.Уранбайгаль: Санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. **“АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрөх тухай” асуудлаар:**
Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 705,651,786 ширхэг хувьцаа буюу 99.98%
Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 103,592 ширхэг хувьцаа буюу 0.01%
Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 4,900 ширхэг хувьцаа буюу 0.00%
2. **“АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх төсөл, нэгтгэх гэрээг батлах тухай” асуудлаар:**
Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 158,244,218 ширхэг хувьцаа буюу 99.94%
Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 95,000 ширхэг хувьцаа буюу 0.06%
Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 4,900 ширхэг хувьцаа буюу 0,00%

3. “АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 158,236,109 ширхэг хувьцаа буюу 99.93%

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 103,000 ширхэг хувьцаа буюу 0.07%

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 5,009 ширхэг хувьцаа буюу 0.00%

4. “АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 158,123,755 ширхэг хувьцаа буюу 99.86%

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 215,354 ширхэг хувьцаа буюу 0.14%

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 5,009 ширхэг хувьцаа буюу 0.00%

5. “АПУ ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай” асуудлаар:

Зөвшөөрсөн - нийт саналын эрхтэй хувьцааны 705,660,269 ширхэг хувьцаа буюу 99.99%

Татгалзсан - нийт саналын эрхтэй хувьцааны 95,000 ширхэг хувьцаа буюу 0.01%

Түдгэлзсэн - нийт саналын эрхтэй хувьцааны 5,009 ширхэг хувьцаа буюу 0.00%

Саналын эрхийн 14,966 ширхэг хувьцаатай 7 хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хүчингүйд тооцов.

ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Ц.Эрдэнэбилэг: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

I. АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, шинээр охин компани үүсгэн байгуулахыг зөвшөөрөв. Үүнд:

1. АПУ ХК-ийг дараах нөхцөлөөр тусгаарлах замаар өөрчлөн байгуулж, шинээр охин компани үүсгэн байгуулахыг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй. Үүнд:

- (i) “АПУ ДЭЙРИ” оноосон нэртэй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулах;
 - (ii) АПУ ДЭЙРИ ХХК-ийн эхлэлтийн тайлан баланс, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 546,190,000 (таван зуун дөчин зургаан сая нэг зуун ерэн мянга) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх, нийт 54,619,000,000 (тавин дөрвөн тэрбум зургаан зуун арван есөн сая) төгрөг байхаар тогтоох;
 - (iii) АПУ ДЭЙРИ ХХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааг АПУ ХК нь 100% эзэмших;
 - (iv) АПУ ДЭЙРИ ХХК нь дараах үйл ажиллагааг хугацаагүйгээр эрхлэх:
 - a. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
 - b. Жүүс, ундааны үйлдвэрлэл;
 - c. Сүү, сүүн бүтээгдэхүүн, жүүс, ундааны бөөний болон жижиглэнгийн худалдаа;
 - d. Гадаад худалдаа.
 - (v) АПУ ДЭЙРИ ХХК-ийг Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 33/5 тоот хаягт албан ёсоор байрлан үйл ажиллагаа явуулахыг тогтоох;
 - (vi) АПУ ДЭЙРИ ХХК-ийн үүсгэн байгуулах анхны Дүрмийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу батлах, цаашид тус Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчилсэн найруулгыг батлах.
2. АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. АПУ ХК-ийн балансаас 54,619,000,000 (тавин дөрвөн тэрбум зургаан зуун арван есөн сая) төгрөгийн хөрөнгийг тусгаарлаж, АПУ ДЭЙРИ ХХК-ийн балансанд шилжүүлж хуваах балансыг гаргахыг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.
4. АПУ ХК-ийн балансаас хөрөнгө тусгаарласантай холбоотойгоор АПУ ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, нийт гаргасан энгийн хувьцааны нэрлэсэн үнэ, тоо хэмжээнд өөрчлөлт орохгүй болохыг дурдсугай.
5. Тусгаарлах нөхцөл, журмыг хэрэгжүүлж ажиллах комисс томилох, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой үүссэн асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах бүрэн эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.

6. АПУ ДЭЙРИ ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх, АПУ ДЭЙРИ ХХК-ийг үүсгэн байгуулах бүрэн эрхийг АПУ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
7. АПУ ХК-ийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулах, охин компани байгуулахтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

II. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрч болон түүнтэй холбогдох дараах хэлэлцсэн асуудлуудыг батлав. Үүнд:

1. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, Эвэргрийн Инвестментс ХХК-ийн үйл ажиллагааг зогсоон, эрх, үүрэг, хариуцлагыг АПУ ХК-д шилжүүлэн нэгтгэсүгэй.
2. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл (цаашид “нэгтгэх төсөл” гэх)-ийг нэгдүгээр хавсралтаар, АПУ ХК ба Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хооронд байгуулагдах Нэгтгэх гэрээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, уг их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхийг зөвшөөрсүгэй.
3. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрсөнтэй холбогдуулан АПУ ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 32,130,455.30 төгрөгөөр нэмэгдүүлж, АПУ ХК-аас дараах төрөл, үнэ, тоо ширхэг бүхий хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргасугай.
Үүнд:

1) Хувьцааны төрөл:	энгийн;
2) Тоо ширхэг:	321,304,553 ширхэг
3) Нэгж хувьцааны үнэ:	1,052.35 төгрөг;
4) Хувьцааны нэрлэсэн үнэ:	10 мөнгө.
4. Эвэргрийн Инвестментс ХХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 338,127,000 ширхэг хувьцааг АПУ ХК-ийн 10 мөнгөний нэрлэсэн үнэтэй 321,304,553 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэн компаниас нэмж гаргасан хувьцааг хаалттай хүрээнд буюу Эвэргрийн Инвестментс ХХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн Эвэргрийн Инвестментс ХХК-д эзэмшиж

буй хувьцааны тоонд хувь тэнцүүлэн дараах хувь хэмжээгээр эзэмшүүлэхийг зөвшөөрсүгэй.

№	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо, ширхэг	Хувьцааны нэгж үнэ	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хувь нийлү үлсэн хөрөнг өнд эзлэх хувь
1	Хайнекен Азиа Пасифик Пти. Лтд	266,091,981	10 мөнгө	26,609,198.10₮	25.00%
2	Монголиан бэвэриж инвестментс ХХК	55,212,572	10 мөнгө	5,521,257.20₮	5.19%
	Нийт	321,304,553	10 мөнгө	32,130,455.30₮	30.19%

- АПУ ХК-д Эвэргрийн Инвестмент ХХК-ийг нэгтгэхтэй холбоотойгоор АПУ ХК-аас хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг АПУ ХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- АПУ ХК-ийн Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг гуравдугаар хавсралтаар баталсугай.
- АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх нөхцөл, журмыг хэрэгжүүлж ажиллах комисс томилох, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах болон их хэмжээний хэлцэл хийгдсэнтэй холбоотой хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх журмыг батлах, хувьцааг эргүүлэн худалдан авах үнийг тогтоох, энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүнтэй холбоотой үүссэн асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
- АПУ ХК ба Эвэргрийн Инвестментс ХХК-ийн хооронд байгуулагдах Нэгтгэх гэрээнд АПУ ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Эрдэнэбилэг)-д олгосугай.
- АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотойгоор Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

10. АПУ ХК-д Эвэргрийн Инвестментс ХХК-ийг нэгтгэх замаар компанийг өөрчлөн байгуулах, АПУ ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг бүртгэх шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөн, нэмэлт хувьцаа бүртгэгдсэний дараа компанийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Эрдэнэбилэг)-д даалгасугай.

Ээлжит бус хурлыг хаав.

Хурал 16 цаг 45 минутад дуусав.

ХЯНАСАН:

Хурлын дарга



Ц.Эрдэнэбилэг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн
Нарийн бичгийн дарга



Ч.Ариунсан